

Ерөнхий мэргэжлийн эмчийн мэргэжлээр эмчлэх зөвшөөрөл олгох шалгалтын жишиг сорил

Хувилбар -10

1. Нэг сонголттой тест (Зөвхөн 1 хариулт зөв байх) Энэ хэлбэрийн сорил нь А, В, С, D, E гэсэн дугаартай бөгөөд Зөвхөн 1 зөв хариуг сонгоно.

2. Олон сонголттой тест (Хэдэн ч хариулт зөв байж болох)

1, 2, 3 дугаар хариултууд зөв бол (A.)

1 ба, 3 дугаар хариултууд зөв бол (B.)

2 ба 4 дугаар хариултууд зөв бол (C.)

Зөвхөн 4-р хариулт зөв бол (D.)

Бүх хариулт зөв бол (E.)

3. Шалтгаан хамаарлын тест (Заагдсан тестүүдийн үнэн зөв хийгээд тэдгээрийн шалтгаан хамаарлыг тодорхойлно.)

Зөв, Зөв, Зөв (A.)

Зөв, Зөв, Буруу (B.)

Зөв, Буруу, Буруу (C.)

Буруу, Зөв, Буруу (D.)

Буруу, Буруу, Буруу (E.)

/1./ Уушгины архаг бөглөрөлт өвчинтэй холбоотой буруу тодорхойлолтыг сонгоно уу:

А. Хурц сэдрэлийн үед өдөр тутам хэрэглэдэг эмүүдийг солино

В. Теофиллин хурц сэдрэлийн эмчилгээний гол бүрэлдэхүүн хэсэг юм

С. Богино хугацааны үйлдэлтэй ингаляцийн β2-агонист хурц сэдрэлийн эмчилгээний гол хэсэг юм

Д. Сэдрэлийн үед ингаляцийн эмүүдийг небулайзер эсвэл туналагдсан аэрозолийг спейсерээр дамжуулан хэрэглэж болно

Е. Богино хугацааны үйлдэлтэй ингаляцийн β2-агонист ба антихолинерг эмүүдийг хавсран хэрэглэхэд дангаар хэрэглэснээс илүү гуурсан хоолой тэлэх үйлдэл үзүүлдэг

/2./ Сүрьеэгийн каверныг уушгины буглаанаас ялгах шинжийг тодорхойлно уу:

А. Хөндий цацагдсан голомтуудын хамт

В. Гөлгөр ханатай, шингэний түвшинтэй хөндий

С. Цустай цэр гарна

Д. Хордлогын шинж

Е. Эритроцитын тунах хурд ихсэх

/3./ Анафилаксийн үеийн антиген юу байж болох вэ?

А. Вирус

В. Ургамлын тоосонцор

С. Шилжүүлэн суулгасан эрхтэн

Д. Нян

Е. Гаптен

/4./ Уушгины том хэмжээний нээгдсэн буглааны үед дараахаас бусад шинжууд гарна:

А. Цэрний хэмжээ ихсэх

В. Хордлогын шинжууд багасах

С. Голомтотнд тогшилтын дуу богиноч, амьсгал суларсан

Д. Голомтонд тогшилтоор хэнгэргэн дуутай, гуурсан хоолойн эсвэл амфорын амьсгалтай

Е. Биеийн халуун буурах

/5./ Уушгины цус алдалтын гол аюул юунд орших вэ?

А. Амьсгалын хурц дутагдал

В. Геморрагийн шок

С. Аспираци, асфиксии

Д. Халдвэр нэгдэх

Е. Зүрхний хурц дутагдал

/6./ Уушгины их хэмжээний цус алдалтын үед ямар арга хэмжээ авах вэ?

1. Бронхоскопи хийж, гуурсан хоолойг бөглөх

2. Ганглиоблокатор хийх

- 3. Мэс засал
- 4. Пневмоперитонеум
- 5. 5. Эмийн эмчилгээ

/7./ Транссудатын шалтгааныг сонгоно уу.

- 1. СКВ
- 2. Нефроз хам шинж
- 3. Лимфом
- 4. Гипотиреоз
- 5. Сүрьеэз

/8./ Ушгины архаг бөглөрөлт өвчний оношийг дараах шинжүүдийн үндсэн дээр сэжиглэж болно:

- 1. Тогтвортой амьсгаадах, цээж шуугих, ханиаж, цэр гарах
- 2. Удаан хугацаанд тамхи татсан байх
- 3. Өвчин аажим даамжрах
- 4. Өвчтөн 50-иас дээш настай байх
- 5. Гуурсан хоолой бөглөрөх шинж бүрэн арилахгүй байх

/9./ Ушгины үрэвслийн нийтлэг бус үүсгэгч юу вэ?

- 1. Микоплазм
- 2. Легионелл
- 3. Хламиди
- 4. Томуугийн вирус
- 5. Цитомегаловирус

/10./ Гялтангийн хөндийд цусархаг шингэн хурах шалтгааныг нэрлэнэ үү.

- 1. Ушгины хавдар
- 2. Ушгины артерийн бүлэнт бөглөрөл
- 3. Ушгины сүрьеэз
- 4. Цээжний гэмтэл
- 5. Гепарин эмчилгээ

/11./ Ямар эмгэгийн үед рентген шинжилгээнд Ходсоны шинж илрэх вэ?

- A. Пиелонефритийн хатингаршил
- B. Бөөрний уйланхай
- C. Бөөрний поликистоз
- D. Бөөрний түүдгэнцэрийн үрэвсэл
- E. Бөөрний чулуу

/12./ Артерийн гипертензийн хожуу үед шээсэнд гарах өөрчлөлт

- A. Лейкоцитури
- B. Гематури+глюкозури
- C. Протейнури+гематури
- D. Оксалатури
- E. Гипостенури

/13./ Жирэмсэний пиелонефриттэй эмэгтэйчүүдийн жирэмсэний явц төрөлтийн үед доорхи хүндрэл нэгээс бусад нь гарч болно

- A. Хожуу үеийн хордлого
- B. Үр зулбалт
- C. Ургийн халдварт хүндрэлүүд
- D. Ургийн гипертрофи илрэх
- E. Бактеремийн шок

/14./ Хүүхэд шөнө орондоо шээхийг юу гэж нэрлэх вэ?

- A. Олигоури
- B. Дизури
- C. Никтури
- D. Странгури
- E. Энурез

/15./ Гликокаликс гэж аль ойлголтыг нэрэлдэг вэ

- A. Подоцитийн элемент
- B. Мезангийн элемент

С. Суурин мембрани хасах цэнэгтэй хэсгүүд

D. Ялгаруулах аппарат

E. Ренин

/16./ Бөөрний цочмог дутагдалыг шалтгаанаар нь яаж ангилдаг вэ?

1. Шокийн гаралтай
2. Хордлогын гаралтай
3. Халдвэр хордлогын гаралтай
4. Бөөрний судасны бөглөрлийн улмаас үүсэх
5. Шээсний замын бөглөрлийн улмаас үүсэх

/17./ БАӨ-өөр өвдөх эрсдэл өндөртэй хүмүүст авах арга хэмжээ

1. 12 сард 1 удаа эмнэлзүйн үзлэг
2. ЦЕШ, ШЕШ, ТШХ хянах
3. ЦД хянах, ШЕШ, ТШХ
4. 6 сард 1 удаа эмнэлзүйн үзлэг
5. Хэвтүүлж өмчлэх

/18./ Түүдгэнцэрийн шүүлтийн үйл ажиллагаанд оролцдаг бүтцүүдийг нэрлэнэ үү?

1. Подоцит эс
2. Суурин мембран
3. Эндотель эс
4. Мезангийн эс
5. Боуман-Шумлянскийн капсул

/19./ Бөөрний экскретор уrogramд дараах зүйлийг тодруулна

1. Бөөрний байрлал
2. Бөөрний аяганцар тэвшинцэрийн байдал
3. Бөөрний хэмжээ
4. Үйл ажиллагааны байдал
5. Ренокортикаль индекс

/20./ Нефроз хам шинжийг явцаар нь яаж ангилдаг вэ?

1. Аажим явцтай
2. Цочмогдуу явцтай
3. Даамжрах явцтай
4. Архагших явцтай
5. Цочмог явцтай

/21./ Бөөрний цочмог дутагдлын III үед түүдгэнцрийн шүүлт сэргэж, сувганцрын регенараци явагдана. Сувганцарын регенарацитай холбоотой сувганцарт К-ийн эргэн шимэгдэлт ихсэж өвчтөнд гиперкалиемийн шинж илэрч их шээнэ.

/22./ БАД-ын үед электролитын солилцоонд хямрал үүсч сийвэнгийн кали ихэсдэг тул 5%-ийн 100-200 мл глюкозын уусмалыг инсулины хамт судсаар тарина. Инсулин эсийн гаднах шингэний калийг эсийн дотор орох нөхцлийг бүрдүүлж цусан дахь калийн хэмжээ буурдаг.

/23./ Ходоод дээд гэдэсний шархлаа өвчний дурангийн шинжилгээгээр All- /Active stage-II/ үрэвслийн идэвхжил II үед ямар өөрчлөлт илрэх вэ?

А. Шархны хэмжээ багасна, ёроол өргөгднө, фибринэн өнгөр нимгэрсэн байна. Амбулаторийн нөхцөлд эмчилнэ.

Б. Шархны ёроол гүнзгий фибринэн өнгөтэй, нэг хоёр хуниас харагдана. Ирмэгний өнгө цайвар, хөөнгө багассан. Энэ үед дотрын эмчийн хяналтанд эмчилгээ хийнэ

С. Шарх хэмжээгээрээ нэлээд багасч конвергенц үүссэн, ёроолын өнгөр нимгэрэн улайлт, грануляци үүссэн байна. Амбулаторийн нөхцөлд эмчилнэ.

Д. Шархны ёроол гүнзгий, фибрин болон гематины бүрхүүлтэй, ирмэг нь өргөгдсөн, гүнзгий улаан өнгөтэй, хөөнгө хавантай. Энэ үед шархлааны цус алдаж болзошгүй байдаг учир мэс заслын эмчийн хяналтанд эмчилгээ хийдэг.

Е. Шарх хэмжээгээр жижгэрч ёроолын өнгөр арилан цэвэршсэн, улайлт, грануляци, конвергенц тод үүссэн, улаан сорви үүснэ. Амбулаторийн нөхцөлд эмчилнэ.

/24./ Ходоод, улаан хоолойн сөөргөө урсгалын өвчний шалбархайт хэлбэрийн “С” зэргийн үед дуранд ямар өөрчлөлт илрэх вэ?.

- A. Улаан хоолойн доод хэсэгт 5 мм хүртэл хэмжээтэй шалбархай 1 ба 2 хананд илрэх.
- B. Улаан хоолойн доод хэсэгт 5 мм- с их хэмжээтэй шалбархай 1 ба 2 хананд үүсэх.
- C. Шалбархайнууд хоорондоо нийлж улаан хоолойн доод хэсгийн гадаргуугын 65% хүртэл талбайг хамрах
- D. Шалбархайнууд хоорондоо нийлж улаан хоолойн доод хэсгийн гадаргуугын 75% хүртэл талбайг хамрах
- E. Шалбархай, шархлаа нь улаан хоолойн доод хэсгийн гадаргуугийн 75%-с их талбайг эзлэх, цус алдалт, сорвижил, нарийсал, эдийн хувирал, шархаар хүндрэх

/25./ Анхдагч билиар циррозын үед ямар эсрэг бие үүсдэг вэ?

- A. AMA
- B. ANA
- C. SMA
- D. p-ANCA
- E. Anti-LP

/26./ Хodoодны дээд хэсэгт байршилтай шархлааны үед хэвлийн аль хэсэгт ямар өвдөлт илрэх вэ?

- A. Аюулхай орчим хоол идсэнээс 20 минутын дараа эрт өвдөлт илрэнэ
- B. Аюулхай орчим хоол идсэнээс 30 минутаас 1 цагийн дараа эрт өвдөлт илрэнэ
- C. Аюулхай орчим хоол идсэнээс 30 минутаас 1 цагийн дараа хожуу өвдөлт илрэнэ
- D. Аюулхай орчим хоол идсэнээс 1 цагийн дараа хожуу өвдөлт илрэнэ
- E. Аюулхай орчим хоол идсэнээс 1 цаг 30 минутын дараа хожуу өвдөлт илрэнэ.

/27./ Антибиотек замбараагүй хэрэглэсний дараа тохиолддог бүдүүн гэдэсний хуурамч өнгөр бүхий / псевдомембранизмын колит/ үрэвсэл ямар үүсгэгчээр үүсдэг вэ?

- A. Салмонелл
- B. Шигелл
- C. Протей
- D. Клостридии диффицилле
- E. Амеб

/28./ Бүдүүн гэдэсний шархлаат үрэвслийн хүндрэлийг нэрлэнэ үү?

- 1. Хавдарт шилжих
- 2. Гэдэсний хордлогот тэлэлт
- 3. Цус алдах
- 4. элэг томрох, шарлах
- 5. Гэдэсний түгжрэл

/29./ Нарийн гэдэсний хананы бүтцэд аль нь орохгүй вэ?

- 1. Tunica submuscularis
- 2. Tunica intermucosa
- 3. Tunica duodenum
- 4. Tunica submucosa
- 5. Tunica mucosa

/30./ Улаан хоолойн сөөргөө өвчний үед баримтлах гам дэглэмийг сонгоно уу?

- 1. Унтахаас 3-4 цагын өмнө хооллохгүй байх
- 2. Хоолломогц хэвтэх буюу унтахгүй байх
- 3. 15—20 см өндөр дэр дэрлэж байх
- 4. Бариу хувцас, бүс, тэлээг хэрэглэхгүй байх
- 5. Тамхи, архи хэрэглэхгүй байх

/31./ Нарийн гэдэсний шимэгдэлт алдагдлыг тодорхойлох шинжилгээ?

- 1. Захын цусанд гемоглобин, эритроцит үзэх
- 2. Өтгөнд стеотория, керетория тодорхойлох
- 3. Чихрийн ачаалалтай сорил
- 4. Д-ксплиозын сорил
- 5. Халуун шээсэнд амилаза үзэх

/32./ Хodoодны урд хананы шарх голчлон ямар эрхтэн рүү нэвчих вэ?/

- 1. Бага чацаархай руу голдуу нэвчинэ
- 2. Элэг рүү голдуу нэвчинэ
- 3. Нойр булчирхайн толгойн хэсэг рүү нэвчинэ

4. Нойр булчирхайн их бие рүү голдуу нэвчинэ
5. Цөсний хүүдий рүү голдуу нэвчинэ

/33./ Кроны өвчин болон Өвөрмөц бус шархлаат колит хоёр нь хоорондоо нилээд төстэй эмгэг юм. Иймээс эмнэлзүйн илрэл, эрхтэн хамрах байдал, эмгэг бүтэц зүй, удамшил зэрэг шинжээрээ ялган оношлодог.

/34./ Бүдүүн гэдэсний хамгаалах үүрэг нь түүний нянгийн бичил орчинтой шууд холбоотой. Иймээс баах үед хэвлүүн ханын булчингууд агшсанаар баас шулуун гэдэс рүү шахагдан орно.

/35./ Чихрийн шижин хэвшинж 2-ийн үеийн эмнэлзүйн шинжийг нэрлэ

- A. Оношлогдох үед ихэвчлэн кетоацидозын байдал илэрсэн байна
- B. Шээс цусанд кетоны бие илэрнэ
- C. Бодисын солилцооны ацидоз илэрнэ
- D. Нүд бүрэлзэнэ
- E. Хүүхэд ба залуу насанд элбэг тохиолдоно

/36./ Санамсаргүйгээр цусны глюкозыг тодорхойлоход хэд гарвал ЧШ гэж оншлох вэ?

- A. 5.4 ммоль/л
- B. 6.6 ммоль/л
- C. 7.0 ммоль/л
- D. 11.1 ммоль/л
- E. бүгд буруу

/37./ Тархмал хордлогот бахуугийн үед мэдрэлийн тогтолцооны талаас илрэх өөрчлөлтийг хэлнэ үү

- A. нойрмог
- B. мартамхай
- C. ой тогтоолт муудах
- D. психоз илрэх
- E. үгээ зөөж, удаан ярих

/38./ Гипогликемийн комын үед хэрэглэдэг “Глюкаген”-ы /глюкагон/ тун

- A. 0.1мг
- B. 0.5мг
- C. 1.0мг
- D. 2.0мг
- E. 10мг

/39./ Тархмал хордлогот бахуугийн үед илрэх эмнэлзүйн шинжийг сонгоно уу

- A. Булчингийн чангарал
- B. Брадикарди
- C. Таталт
- D. Пульсийн даралт ихсэх
- E. Зүрхний авиа бүдэг

/40./ Таргалалтын үед дараах дааврын өөрчлөлтүүд үүснэ

1. Гипертреодизм
2. Гипотреодизм
3. Гиперкортицизм
4. Гипогонадизм
5. Гиперпаратреодизм

/41./ Тархмал хордлогот бахуугийн үед илрэх зовиурыг нэрлэ

1. Бие нозоорох
2. Халууцах
3. Даарах
4. Өлсөх
5. Хавагнах

/42./ Гипокортицизмын үед аменоррэй болно. Яагаад гэвэл гипокортицизмын үед альдостерон багасдаг.

/43./ Зүрхний дутагдлыг эрт илрүүлэх зорилгоор ямар шинжилгээг хийвэл илүү үр дүнтэй вэ?

- A. Зүрхний хэт авиан шинжилгээ
- B. Зүрхний ачаалалтай сорил
- C. Тропонин
- D. Натри ялгаруулагч пептид
- E. Зүрхний сцинографи

/44./ Дараах бэлдмэлүүдээс аль нь артерийн даралт бууруулах, миокардын хүчилтөрөгчийн хэрэгцээг багасгах, зүрхний хэм алдагдал засах үйлчилгээтэй вэ?

- A. Лизиноприл
- B. Атенолол
- C. Изосорбид
- D. Амиодарон
- E. Нифедипин

/45./ Аль нь Х хам шинж вэ?

- A. Стенокардийн өвдөлт илэрсэн боловч миокардын ишемийн шинж тэмдэг ЗЦБ-т илрээгүй
- B. Стенокардийн өвдөлт илэрч, сийвэнд ферментийн идэвхжил ихэссэн боловч титэм судасны рентген шинжилгээ хэвийн
- C. Стенокардийн өвдөлт илэрч, миокардын ишемийн шинж тэмдэг ЗЦБ-т илрээгүй боловч титэм судасны рентген шинжилгээ эмгэг өөрчлөлттэй
- D. Стенокардийн өвдөлттэй, миокардын ишемийн шинж тэмдэг ЗЦБ-т илэрсэн боловч титэм судасны рентген шинжилгээ хэвийн
- E. Стенокардийн өвдөлтгүй, миокардын ишемийн шинж тэмдэг ЗЦБ-т илрээгүй боловч титэм судасны рентген шинжилгээ эмгэг өөрчлөлттэй

/46./ Зүрхний архаг архаг дутагдлын Америкийн Зүрхний Холбооны ангиллаар “С” үе шатанд илрэх шинжийг нэрлэнэ үү?

- A. Зүрх судасны эрсдэлт хүчин зүйлс илэрсэн байх
- B. Биеийн хүчний ачаалалын үед зүрхний дутагдлын эмнэл зүйн шинж илрэх
- C. Зүрхний бүтцийн өөрчлөлт илрэсэн боловч зүрхний дутагдлын эмнэл зүйн шинж тэмдэггүй байх
- D. Зүрх бүтцийн өөрчлөлттэй, зүрхний дутагдлын шинж тайван үед тод илрэх
- E. Зүрхний бүтцийн өөрчлөлтэй байх, зүрхний дутагдлын шинж тэмдэг илрээд удаагүй байх

/47./ Титэм судасны дотуурх эмчилгээ хийх үед том молекулт гепариниг ямар үзүүлэлтийн хяналтан дор хэрэглэдэг вэ?

- A. A PTT
- B. АСТ
- C. INR
- D. TT
- E. Фибриноген

/48./ Ямар тохиолдолд ЗЦБ-ийн V5- V6 холболтонд ишемийн бус гаралтай ST сегментийн өөрчлөлт гарч болох вэ?

1. Гисийн баруун багцын хориг
2. Гисийн зүүн багцын хориг
3. Баруун ховдлын гипертрофи
4. Зүүн ховдлын гипертрофи
5. Перикардит

/49./ Ямар тохиолдолд зүрхний архаг дутагдлын эмчилгээнд дигоксиныг хэрэглэдэг вэ?

1. Мерцательны тахиаритми хавсарсан тохиолдол
2. Ишемийн гаралтай зүрхний дутагдал
3. Цацалтын үзүүлэлт <25%
4. Өөр бүлгийн эмийн бэлдмэл үр дүнгүй үед

5. Зүрхний шигдээсийн үеийн дутагдал
- /50./ Амигуулах суурь тусламжийг хэдий хүртэл үргэлжлүүлэх вэ?
1. Мэргэшсэн тусламж иртэл
 2. Аврагч өөрөө цуцаж туйлдах хүртэл
 3. Өвтөн өөрөө хэвийн хэвийн амьсгалтай болох хүртэл
 4. Таван минут
 5. Гүрээний лугшилт тэмтрэгдэж эхлэх
- /51./ Халдварт эндокардитыг нотлох оношлогооны шалгуурыг сонгох
1. Зүрхний хэт авиан шинжилгээгээр хавхлага орчимд ургацаг илрэх
 2. Лейкоцитоз
 3. Бактериеми
 4. Улаан эсийн тунах хурд ихсэх
 5. С урвалжит уураг ихсэх
- /52./ Гипотензив үйлчилгээтэй бэлдмэл АД бууруулахгүй бол ямар арга хэмжээ авах вэ?
1. Эмийн тунг нэмнэ
 2. Эмийг хасна
 3. Эмийг хасахгүйгээр даралт бууруулах өөр эм нэмж өгөх
 4. Эмийн бус эмчилгээ эхлэх
 5. Эмийг үргэлжлүүлэн өгнө
- /53./ Зүрхний шигдээсийн үед титэм судасны бүлэн үүсдэг. Стрептокиназа бүлэн хайлуулдаг.
- /54./ Өвчтний захын цусны дэлгэрэнгүй шинжилгээнд хүнд зэргийн нормохромын нормоцитын цус багадалт, лейкоцит 32*10⁹/л, ялтас 1233*10⁹/л захын цусны түрхэцд бөөм агуулсан улаан эс, миелоцит, нулимсны дусал хэлбэрийн эритроцит, аварга тромбоцитууд ба мегакариоцитын хэлтэрхий харагджээ.
- Та ямар эмгэгийг сэжиглэж байна вэ?
- A. Хурц миелобластын лейкеми /M5/
 - B. Архаг миелолейкоз
 - C. Жинхэнэ тромбоцитеми
 - D. Анхдагч миелофиброз
 - E. Цочмог миелофиброз /M7/
- /55./ Аплазын цус багадалтыг батлахад ямар шинжилгээ хамгийн их ач холбогдолтой вэ ?
- A. Ясны хэмийн эсийн шинжилгээ
 - B. Ясны хэмийн эдийн шинжилгээ
 - C. Цитологийн шинжилгээ
 - D. Иммунологийн шинжилгээ
 - E. Рентген шинжилгээ
- /56./ Архаг лимфолейкозын үед эмчилгээний ямар зарчим барих вэ?
- A. Монохими эмчилгээг гидроксиуреа эмээр хийнэ
 - B. Монохими эмчилгээг хлорбутин эмээр хийнэ
 - C. Полихими эмчилгээг 7+3 хөтөлбөрөөр хийнэ
 - D. Полихими эмчилгээг ТАД-9 хөтөлбөрөөр хийнэ
 - E. Монохими эмчилгээг сарколизинээр хийнэ
- /57./ Ямар өвчний үед сийвэнгийн ферритин багасаж, сийвэнгийн нийт тэмэр холбох чадвар ихсэх вэ?
- A. Фолийн хүчил дутагдлын цус багадалт
 - B. Архаг цус алдалтын улмаас үүссэн тэмэр дутлын ЦБ
 - C. Далд хэлбэрийн тэмэр дутлын цус багадалт
 - D. Вит B12 дутлын цус багадалт
 - E. Гипоаплазийн цус багадалт
- /58./ Миелома өвчний үед гардаггүй шинж?
- A. Сээр нурууны остеопороз
 - B. Протейнури
 - C. Гиперпротейнеми
 - D. Халдварт хүндрэл үүсэх

Е. Захын цусанд лимфоцит ихсэх

/59./ Цус бүлэгнэлтийн анхдагч гемостазын үе шатуудыг нэрлэнэ үү?

1. Гэмтсэн судас агших үе
2. Ялтас наалдах (адгези) үе
3. Ялтсын бөөгнөрөл (агрегаци) үүсэх үе
4. Ялтсын бүлэн үүсэх үе
5. Ялтсын бүлэн задрах үе

/60./ Мегалобластын цус багадалтанд дараах эмгэгүүд орно.

1. Витамин B12 дутагдлын цус багадалт
2. Фолийн хүчил дутагдлын цус багадалт
3. ДНХ-ийн нийлэгжилтийн төрөлхийн дутагдал
4. Эритролейкеми
5. Тусмал сидеробластын цус багадалт

/61./ 1800гр жинтэй төрсөн нярайг хэддүгээр зэргийн дутуу гэж үзэх вэ?

- A. I зэрэг
- B. II зэрэг
- C. III зэрэг
- D. IV зэрэг
- E. V зэрэг

/62./ Аарцгийн сэргийн хоорондох зайд /Dis. Spinarum / хэд байх ёстой вэ?

- A. 10-15
- B. 15-19
- C. 20-21
- D. 25-26
- E. 27-30

/63./ Умайн үйл ажиллагааны цус алдалт үүсэх нөхцөл нь:

- A. Бэлгийн дааврын хэмжээ ер бусын байдлаар өөрчлөгдөх
- B. Бэлгийн даавар ялгарах динамик явц алдагдах
- C. Умайн салстрын бүтцийн өөрчлөлт
- D. Умайг салстрын цусан хангамжийн хямрал
- E. Умайг салстрын үрэвсэл

/64./ Хэвийн жирэмсний явцад цусны эргэлтэнд гарах өөрчлөлт ?

1. Эргэлдэх цусны хэмжээ 35-40 % нэмэгдэнэ
2. Улаан эсийн тоо 30-40 % нэмэгдэнэ
3. Цус шингэрнэ
4. Гемоглобины хэмжээ 40-50% нэмэгдэнэ
5. Цагаан эсийн тоо 15-20% буурна

/65./ Манас таталтын урьдлын хүнд хэлбэрийн үед өрхийн эмч ямар тусламж үзүүлэх вэ?

1. Ачааллаа багасгахыг зөвлөнө
2. Долоо хоногийн дараа давтан үзүүлэхийг зөвлөнө
3. Долоо хоногийн дараа даралт их байвал эмнэлэгт хэвтүүлэхийг сануулна
4. Магнийн сульфат хийж эмнэлэгт яаралтай хэвтүүлнэ.
5. Ампициллин тарина.

/66./ Тээвэрлэх болон гэрийн төрөлтийн үеийн яаралтай тусламжинд ямар хэрэгслүүд зайлшгүй шаардлагатай вэ?

1. Судасны катетр ба систем
2. Бээлий, шээлгүүр
3. Ариун тариур, зүү, үжилгүйжүүлэх уусмал
4. Хог хийх уут, ихэс хийх пластик сав.
5. Гар чийдэн, нөөц зайд

/67./ Паразозфагеал ивэрхийн талаар ямар ойлголт буруу вэ?

- A. Амь насанд аюултай байжболно.
- B. Өвчүүний цаана хорсож их өвдөх
- C. Уг өвчин гэдэсний түгжрэлийг үүсгэнэ.
- D. Ходоодны хавчигдсан хэсэг цоорч, үхжил үүсгэж болно.
- E. Хэвтээ байдалд өвдөлт нэмэгдэнэ.

/68./ Улаан хоолойн цүлхэнгийн ангилалд аль нь хамаардаг вэ?

- A. Гэмтлийн
- B. Үрэвслийн
- C. Нэвчтэст
- D. Татагдсан /тракционный/
- E. Холимог

/69./ Кроны өвчтэй гэдсэндээ уруул хэлбэрийн бүрэн цоорхойтой 42 настай өвчтөнийг эмчлэх оновчтой аргыг заана уу?

- A. Колченоговын бөглөгчөөр цоорхойг бөглөх
- B. Сорогчийг хэрэглэх
- C. Эмийн эмчилгээ хийж, гуурсаар хооллох
- D. Цоорсон гэдэсний хэсгийг тайрч, гэдэсийг хооронд нь залгах
- E. Мельниковын аргаар гэдэсний 3/4-ийг тайрч цоорхойг оёх

/70./ Өвчтөнөөс эмчид халдварт дамжих үйл явцад хамаarahгүй хүчин зүйлийг нэрлэнэ үү?

- A. Өвчтөн халдварт үүсгэгч нян, вирустай байх
- B. Өвчтөний цус, шингэн эмчийн биед нэвтрэх зам байх
- C. Өвчтөн эмгэг өвчнөөр халдвартлагдсан өгүүлэмж
- D. Эмчийн биед халдварт үүсгэхүйц олон тооны нян нэвтэрч орох
- E. Эмчийн дархлаа сул байх

/71./ Гэмтсэн өвчтөнийг шаардлаггүй үед хөдөлгөж, зөөхөд ямар сөрөг нөлөө гарч болох вэ?

- 1. Хугарсан яс арьсийг цоолох
- 2. Хугарсан яс зөөлөн эд, судас гэмтээх
- 3. Цус алдалтыг нэмэгдүүлэх
- 4. Шарханд халдварт орох
- 5. Өвдөлт нэмэгдүүлэх

/72./ Морфиныг уух, тарихын харьцаа ямар байдаг вэ?

- A. 1:1
- B. 2:1
- C. 3:1
- D. 1:3
- E. 1:4

/73./ Амьдралын төгсгөлийн шатанд буй өвчтөний дотор муухайрч бөөлжих шалтгаан:

- 1. Өмөнгөөс шалтгаалж хodoод саажих, хodoодонд цус хурах, гэдэс түгжрэх, хэвлийн хөндийд шингэн хурах, элэг томрох
- 2. Гиперкальциеми, гипонатриеми, бөөрний дутагдал, хавдрын хордлого
- 3. Хими, цацраг эмчилгээний дараа
- 4. Эмийн эмчилгээнээс /аспирин, антибиотик, кортикостероид, хар тамхины бэлдмэлүүд

Г.М./

- 5. Ходоодны үрэвсэл, шархлаа, хавдар

/74./ Сул сааны үед гэмтэх бүтцүүд

- A. Нугасны арын эвэр
- B. Нугасны өмнөд эвэр
- C. Нугасны хажуу эвэр
- D. Ganglion spinal
- E. Premotor cortex

/75./ Мэдрэхүйн тэнцвэргүйдлийн бүтцүүд

- 1. Нугасны арын багана
- 2. Хязгаарын олон мэдрүүлүүд
- 3. Tr.bulbo-thalamicus
- 4. Бага тархи
- 5. Духны дэлбэн

/76./ Төвийн гаралтай хорт хавдарыг ямар хэлбэрийн сурьеэгээс ялган оношлох шаардлагатай вэ?

- A. Цээжний хөндийн тунгалгийн булчирхайн сурьеэ
- B. Туберкулема

С. Дугуй нэвчдэст сүрьеэз

D. Хөндийт сүрьеэз

E. Тархмал сүрьеэз

/77./ Сүрьеэгийн нян өсгөвөрлөх шинжилгээний хариу дунджаар хэд хоногийн дараа гарах вэ?

A. 7 хоног

B. 14 хоног

C. 21-56 хоног

D. 2 хоног

E. Дээрхи бүгд

/78./ Туберкулем даамжирч, задарсан тохиолдолд илрэх шинжүүдийг тоочно уу?

1. Цэргий ханиах, цустай ханиах

2. Хордлогын хам шинж тод илрэх

3. Цэрний түрхэц зэрэг гарах

4. Цусны шинжилгээнд өөрчлөлт илэрч, СОЭ хурдах

5. Гэрлийн шинжилгээнд гэмтэлийн хэмжээ томорч, сүүдэр жигд бус болох

/79./ Ушгины хурц милиар сүрьеэгийн үед гэрлийн шинжилгээнд илрэх өөрчлөлтийг тодорхойлно уу?

1. Зөвхөн нэг талын уушгийг нэлэнхүйд нь хамарч жигд бус тархсан

2. Хоёр талын уушгийг нэлэнхүйд нь хамарч жигд тархсан

3. Жижиг болон дунд зэргийн хэмжээтэй голомтууд тодорхойлогдоно

4. Олон тооны шар будаа шиг жижиг голомтууд тодорхойлогдоно

5. Ушгинд “тамгалсан” хөндий үүссэн байна

/80./ Цусан суулга өвчний эмнэлэүйн явц ямар ямар үе шатаар илэрдэг вэ?

A. Урьдал үе, эхлэл үе, ид үе, эдгэрэх үе

B. Урьдал үе, эхлэл үе, ид үе, эдгэрэх үе

C. Эхлэл үе, ид үе, шинж тэмдэг буурах үе, эдгэрэх үе

D. Эхлэл үе, ид үе, эдгэрэх үе

E. Урьдал үе, эхлэл үе, шинж тэмдэг буурах үе, ид үе, эдгэрэх үе

/81./ Гахай хавдар өвчний үүсгэгчийг сонго

A. Риновирус

B. Паромиксовирус

C. Тогавирус

D. Нян

E. Рубивирус

/82./ Гахай хавдрын эгэл хэлбэрийн эмчилгээг тэмдэглэ

1. УВЧ-ээр шарах

2. Бүлээн ба спиртэн бигнүүр

3. Шүлс бага ялгаруулах шингэвтэр хоол

4. Хацарт хүйтэн жин

5. Цус тогтоох эмчилгээ зайлшгүй хийнэ

/83./ Урвах тахал өвчний баасны шинж чанарыг тэмдэглэ

1. Усархаг

2. Хэмжээ их

3. Үнэргүй

4. Цусны судалтай

5. Хоолны үлдэцтэй

/84./ 40-с дээш насанд болрын уян чанар алдагдаж нүдний аккомодацид нөлөөлснөөр тод харах ойрын цэг холдох эмгэгийг нэрлэнэ үү

A. Миопи

B. Гиперметропи

C. Эмметропи

D. Пресбиопи

E. Анизометропи

/85./ Болор ямар давхаргуудаас тогтох вэ?

1. Гадар буюу Холтослог үе

2. Гадна мемброн
3. Дотор үе буюу мөхлөг
4. Шингэн үе
5. Трабекул үе

/86./ Нүдний доод даралтыг тодорхойлох аргыг нэрлэнэ үү?

1. Периметри
2. Эхобиометри
3. Диафонаоскопи
4. Тонометри
5. Пахиметри

/87./ Хөөмийн гүйлсний томролтыг ямар эмгэгээс ялган оношлох вэ?

- A. Залгиурын арын буглаа
- B. Гүйлс орчмын буглаа
- C. Хөөмийн гүйлсний архаг үрэвсэл
- D. Медиастенит
- E. Гүйлсний хорт хавдар

/88./ Хамрын харшил илрүүлэх сорилын хэлбэрүүдийг нэрлэнэ үү

1. Хамрын хөндийн сорил
2. Арьсан дээрхи сорил
3. Арьсан доорхи сорил
4. Хэлний доор дусааж сорил хийх
5. Нүдэнд дусааж сорил хийх

/89./ Хамрын үзүүр, угалз хэсгийн тосны булчирхайн цорго битүүрч, батга өтгөрч, орчны цусны хялгасан судсууд холбогч эдтэй наалдан, хамар хэмжээгээрээ томрох эмгэгийг “боргоцой хамар” гэх (1) бөгөөд үүнийг зөвхөн мэс заслаар л эмчилнэ

/90./ 62 настай малчин эмэгтэй баруун өвдөгрүү хатгуулж өвддөг болсон зовиуртай. Өвдөг ялангуяа шөнийн цагаар их өвддөг. Тэр мал төл авах, хонь түрүүлэх ажил хийдэг ба бээлийгүй гараараа зулбасан малын эхэс хуулдаг байсан гэв. Түүний ээж 78 настайдаа нугасанд сүрьеэгийн хүйтэн буглаатай, өвдөгний сүрьеэтэй байгаад ХӨСҮТ-ийн сүрьеэгийн тасагт 10 жилийн өмнө нас барсан. Нөхөр нь булчирхайн сүрьеэгээр өвчилж, хүзүүний булчирхайнаас идээрхэг шингэн гойжсон тул мэс засал хийлгэж, булчирхайг авахуулсан. Эмэгтэй өөрөө туранхай, хөлрөмтгий, ядрамтгай. Рентген зурагт баруун өвдөгний яс голомтот эмтэрсэн өөрчлөлттэй, зүүн өвдөг остеоартритын шинжтэй. Түүнд ямар эмчилгээ илүү үр дүнтэй вэ?

- A. Антибиотик
- B. Даавар эмчилгээ
- C. Сүрьеэгийн эсрэг эмчилгээ
- D. Аллопуринол эмчилгээ
- E. Гепарин эмчилгээ

/91./ Нас дагаж хүний биеийн судаснууд нарийсан, хатууран, эрхтэн тогтолцооны цусан хангамж муудсанаар ямар өөрчлөлтүүд илэрдэг вэ ?

1. Тархины цусан хангамж муудсанаар тархины жин багасана, ой санамж мууддаг, уймарч будилдаг, настанд зөнөх, тэнэгэрэх шинжүүд илэрдэг.
 2. Нүдний цусан хангамж муудсанаар харааны мэдрэлд өөрчлөлт орж, хараа мууддаг, нүд хуурайших, аргах, нүдний алим багасах, зовхи унах шинжүүд илэрдэг
 3. Чихний цусан хангамж буурснааар сонсголын мэдрэл суларч, сонсгол мууддаг.
 4. Зүрхний цусан хангамж муудсанаар зүрхэнд склерозын процесс явагддаг, зүрхний агшилтын хүч, тоо цөөрдөг.
 5. Бөөрний цусан хангамж муудсанаар бөөрний жин багасч, түүдгэнцэрийн тоо цөөрнө, бөөрний судсаар эргэлдэх цусны хэмжээ багасна, түүдгэнцэрийн ялгаруулалт муудна, шээс ховордоно
- /92./ Настангийн үйл ажиллагааны чадварыг үнэлхэд Карновскийн индекс 100 оноо бол юу гэж үнэлэх вэ?
- A. Эрүүл, зовиургүй, өвчний шинжгүй

- B. Хэвийн үйл ажиллагаа явуулах чадвартай, өвчний ганц нэг шинж илэрсэн.
- C. Маш сул, идэвхитэй дэмжих эмчилгээ шаардлагатай
- D. Үхлүүд, өвчин маш хурдан даамжирч байгаа
- E. Өөрийгөө арчлах чадвар маш муу тул тусгай асаргаа шаарддаг
- /93./ Настан өөртөө үйлчлэх чадвартай ба өдөр тутмын амьдрал хэвийн байгаа эсэхийг шалгахдаа ямар үзүүлэлтүүдийг ашигладаг вэ?
1. Эмийг зөв тунгаар, зөв цагт нь уух, хэрэглэх чадвар
 2. Мөнгө тоолох чадвар ба хоногийн хэрэгцээтэй зүйлийг бие даан эсвэл бусдын тусламжтай худалдан авах чадвар
 3. Утсаар ярихдаа дугаараа өрөө харах, өөрөө залгах, ярих, сонсох, хариулах чадвар
 4. Цалинтай ажил хийх чадвар
 5. Төрийн бус байгууллагад сайн дураараа ажиллах чадвар
- /94./ Яс үений үрэвслийн өмнэлзүйн шинж тэмдэгт тохирохгүйг нэрлэнэ үү.
- A. Үений өвдөлт
 - B. Ye мултрах
 - C. Шажигналт
 - D. Үений хөдөлгөөний далайц буурах
 - E. Үений үйл ажиллагаа алдагдах
- /95./ Хуурамч тулай өвчний үед үений шингэний шинжилгээнд илрэх өөрчлөлтийг нэрлэ.
1. Нитратууд
 2. Кальцидигидропиарат
 3. Кальцигирофосфат
 4. Урат
 5. Гидрокальциурат
- /96./ Эрхтэн тогтолцооны хатуурлын уушигны өөрчлөлтөнд аль шинж байхгүй вэ:
1. Идээт үрэвсэл
 2. Шилэнцэр ойлт
 3. Хавдар
 4. Зөгийн үүрийн шинж
 5. Завсрын эдийн хатуурал
- /97./ ОА ийн РА гаас ялгах өмнэлзүйн шинжуудийг нэрлэнэ үү.
1. Өглөөний хөшингө 40 мин
 2. Удаан алхсаны дараа өвдөлт нэмэгдэх
 3. Удаан суусны дараа хөшиж өвдөх
 4. Гэмтлийн дараа өвдөлт ихсэх
 5. Өглөөний хөшингө цагаас илүү
- /98./ Нуруу нугаламын барьцилдаат спондилитээр ямар хамааралтай хүмүүс өвчлөх магадлалтай вэ.
1. HLA-B37
 2. HLA-DR13
 3. HLA-D27
 4. HLA-B27
 5. HLA-B25
- /99./ Шегрены хам шинжийн тодорхойлолтонд аль шалгуур нийцэх вэ:
1. Нүд хуурайших
 2. Арьс хатуурах
 3. Ам хуурайших
 4. Арьсан дээр нэсөөжилт гарах
 5. Арьсан доор товруу үүсэх
- /100./ Үений үрэвслийн нөхөн төлжилтийн үед үеэр хавдах, ээрүүл хэлбэртэй болох зэрэг шинжүүд илрэх бөгөөд рентгенд үе хоорондын завсан зузаарсан байдаг.

Сорилын зөв хариулт

1-В, 2-А, 3-В, 4-С, 5-С, 6-В, 7-С, 8-Е, 9-А, 10-Е, 11-А, 12-С, 13-Д, 14-Е, 15-С, 16-Е, 17-Б, 18-А, 19-Е, 20-В, 21-Б, 22-А, 23-В, 24-Д, 25-А, 26-В, 27-Д, 28-А, 29-А, 30-А, 31-С, 32-С, 33-А, 34-В, 35-Д, 36-Д, 37-Д, 38-С, 39-Д, 40-Д, 41-С, 42-В, 43-Д, 44-В, 45-Д, 46-Е, 47-Б, 48-С, 49-В, 50-А, 51-В, 52-В, 53-А, 54-Д, 55-В, 56-В, 57-В, 58-Е, 59-А, 60-А, 61-В, 62-Д, 63-В, 64-В, 65-Д, 66-Е, 67-В, 68-Д, 69-Д, 70-С, 71-Е, 72-С, 73-Е, 74-В, 75-А, 76-А, 77-С, 78-Е, 79-С, 80-С, 81-В, 82-А, 83-А, 84-Д, 85-А, 86-Д, 87-С, 88-А, 89-С, 90-С, 91-Е, 92-А, 93-А, 94-В, 95-С, 96-В, 97-С, 98-Д, 99-В, 100-А,